



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/51

Номгон

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг
хэрэгжүүлэх арга хэмжээний 2026 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний 90 дэх заалт, аймгийн Засаг даргын 2026 оны А/25 дугаар “Төсөл хөтөлбөр, бодлого, стратеги хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай” захирамжийн жагсаалтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг сум, байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл хөтөлбөр, бодлого, стратеги хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.
4. Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

625010129

D:\2026\1.Zakhiramj\Zghiramj 01.docx